

БҮРТГЭЛ-ХЯНАЛТЫН КАРТ

Огноо 2020-03-06

МБ

Байгууллагын нэр

Зохион байгуулалтын нэгж,ажилтны нэр

Бүртгэсэн		Хаанаас	Баримт бичгийн		
Сар, өдөр <u>2/06</u>	Карт № <u>493</u>	<u>МБ ТӨХК-ТНУЗ</u>	Дугаар <u>2020/06</u>	Сар <u>4/04</u>	Хуудасны тоо

Товч утга

Журан батлах, мэдээтэй өөрчлөлт оруулах
тухай, хөрөнгөөр баталгаажсан зүйл
цаасны бүртгэлийн жураал

Удирдлагын
заалт

Д. Хандаржа, Н. Мавриан Талар

[Signature]

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн
15 тоот тогтоолын хавсралт

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК-ИЙН
“ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ЖУРАМ”
*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны 2020/06 тоот
Тогтоолоор өөрчлөлт оруулсан./*



Журам батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Үнэт цаасны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.7, 49 дүгээр зүйлийн 49.1.2, 49.1.4, 49.3 дахь заалтууд, Компанийн тухай хуулийн 76 дугаар 76.1.13 дахь хэсэг, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 7.3.16 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 1.4 дэх заалтыг “Биржийн бусад дүрэм, журамд өөрөөр заагаагүй бол хувьцаа, өрийн хэрэгслээс бусад үнэт цаас, санхүүгийн хэрэгслийг бүртгэхтэй холбоотой харилцааг тусгайлсан журмаар зохицуулна” гэж өөрчилсүгэй.
3. МХБ-ийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын 1.1 дэх заалтыг “Энэхүү журмын зорилго нь Монголын хөрөнгийн бирж /цаашид МХБ гэх/-д бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн шинээр болон нэмж гаргасан хувьцаа, өрийн хэрэгсэл болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан бусад санхүүгийн хэрэгслийг анхдагч зах зээлд байршуулах, хуваарилалт хийх, арилжих үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шударга, ил тод, шуурхай явуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино” гэж тус тус өөрчилсүгэй.
4. Баталсан журам болон энэхүү Тогтоолоор өөрчлөлт орсон холбогдох журмуудыг Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулж, батламжлуулахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.
5. “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг Санхүүгийн зохицуулах хорооноос батламжлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.БАТХУЯГ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2018 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн
2018/01 тоот тогтоолын хавсралт

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ” ТӨХК-ИЙН
“ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ”

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны 2020/06 тоот
Тогтоолоор өөрчлөлт оруулсан.*



“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн
Төдөөлөн удирдах зөвлөлийн
2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн
2020/06 тоот тогтоолын хавсралт



**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ” ТӨХК-ИЙН
“ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ”**

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Ерөнхий зүйл

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСЫГ БИРЖИЙН БҮРТГЭЛД БҮРТГЭХ

2 дугаар зүйл. Бүртгүүлэх ажиллагааны бэлтгэл

3 дүгээр зүйл. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгүүлэх хүсэлт гаргах

4 дүгээр зүйл. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулгын агуулга, хэлбэр

5 дугаар зүйл. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Биржид бүртгэх, бүртгэхээс татгалзах

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ШАЛГУУР, ШААРДЛАГА

6 дугаар зүйл. Ерөнхий шалгуур, шаардлага

7 дугаар зүйл. ХБҮЦ гаргагч болон үнэт цаасанд тавигдах шалгуур

8 дугаар зүйл. Шалгуураас чөлөөлөх буюу хөнгөлөх

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БҮРТГЭЛТЭЙ БАЙХ ХУГАЦААНД БИЕЛҮҮЛЭХ ҮҮРЭГ

ТАВДУГААР БҮЛЭГ. ХБҮЦ-НЫ АРИЛЖААГ ЗОГСООХ, БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

ДОЛООДУГААР БҮЛЭГ. ХАРИУЦЛАГА

НАЙМДУГААР БҮЛЭГ. БУСАД

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэгдүгээр зүйл. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид ХБҮЦ гэх)-ыг Монголын хөрөнгийн бирж (цаашид Бирж гэх)-ийн бүртгэлд бүртгэх, бүртгэлийн шалгуур, шаардлагыг тогтоох, бүртгэлтэй байх хугацаанд ХБҮЦ гаргагчийн хүлээх үүрэг, түүнд хяналт тавих, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журмыг Биржийн бүртгэлд бүртгэгдсэн, бүртгүүлэхээр хүсэлт гаргасан ХБҮЦ гаргагч, түүний үүсгэн байгуулагч, Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид ТУЗ гэх/-ийн гишүүн, анхны үүрэг гүйцэтгүүлэгч, худалдагч, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч, аудитор, хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч болон хууль, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид Хороо гэх/-ны холбогдох журмын хүрээнд тодорхойлсон ХБҮЦ гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээд дагаж мөрдөнө.
- 1.3. “ХБҮЦ-ны харилцаанд оролцогч этгээд” гэдэгт Монгол Улсын Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 17 ба 36 дугаар зүйлд заасан анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, үйлчилгээ үзүүлэгч, тусгай зориулалтын компани, хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч болон холбогдох бусад этгээдийг ойлгоно.
- 1.4. Журамд хоёрдмол утга гарсан тохиолдолд Бирж нь журмыг тайлбарлах эрхтэй байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСЫГ БИРЖИЙН БҮРТГЭЛД БҮРТГЭХ

2 дугаар зүйл. Бүртгүүлэх ажиллагааны бэлтгэл

- 2.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь баталгаат үнэт цаас, барьцаат үнэт цаас гэсэн төрөлтэй байх ба уг үнэт цаасыг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Хорооны 2011 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам” /цаашид Хорооны журам гэх/-ын дагуу Хорооны бүртгэлд бүртгүүлсэн байна.
- 2.2. Баталгаат үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Хорооны журамд заасны дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан тусгай зориулалтын компани /цаашид ТЗК гэх/ байна.
- 2.3. Барьцаат үнэт цаас гаргагч нь Хорооноос зөвшөөрөгдсөн, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 26.1-д заасан банк, орон сууцны санхүүжилтийн компани тус тус байна.
- 2.4. Нээлттэй хүрээнд нийтэд санал болгон үнэт цаас гаргах тохиолдолд Хорооны тусгай зөвшөөрөлтэй, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэгч этгээд /цаашид андеррайтер гэх/-тэй гэрээ байгуулан, түүгээр зуучлуулж болно.
- 2.5. Баталгаат үнэт цаас гаргагчийн хувьд бүртгүүлэх ажиллагааны бэлтгэл шатанд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 2.5.1. Үүсгэн байгуулагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т заасан шаардлагыг хангасан этгээд байх;
 - 2.5.2. ТЗК нь анхны үүрэг гүйцэтгүүлэгч, худалдагчтай хөрөнгө шилжүүлэх, худалдах, худалдан авах гэрээ байгуулж, баталгаат үнэт цаас гаргах үед хөрөнгийн багцыг өөрийн хөрөнгөнд бүртгэсэн байх;
 - 2.5.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан, Хорооны журмын нөхцөл шаардлагыг хангасан үйлчилгээ үзүүлэгч этгээдтэй “Үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулсан байх;
 - 2.5.4. Хорооны нөхцөл, шаардлагыг хангасан, тусгай зөвшөөрөл бүхий хөрөнгө итгэмжлэн удирдах этгээдтэй “Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ” байгуулсан байх ба уг этгээд нь бие даасан, ХБҮЦ эзэмшигчдийн эрх ашгийг төлөөлөх болон багцын хөрөнгөтэй холбоотой мэдээлэл авах эрхээр хангагдсан байх;
 - 2.5.5. Баталгаат үнэт цаас гаргагч нь Хороонд бүртгэлтэй хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрхтэй этгээдтэй гэрээ байгуулан, дараах агуулга бүхий дүгнэлтийг гаргуулсан байх. Үүнд:
 - 2.5.5.1. ТЗК-ийг үүсгэн байгуулах ажиллагаа болон түүнийг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн байдал нь хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн, холбогдох шийдвэр, гэрчилгээ, дүрэм зэрэг нь хүчин төгөлдөр эсэх;
 - 2.5.5.2. ТЗК-ийн дүрэм, үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах журам, зааврууд нь хууль тогтоомжид нийцсэн эсэх;
 - 2.5.5.3. Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдтэй буюу энэхүү журмын 2.4, 2.5.2-2.5.4-т заасан холбогдох этгээдүүдтэй байгуулсан гэрээ болон ХБҮЦ гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ хэлцэл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх;
 - 2.5.5.4. ХБҮЦ гаргагч нь үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх;
 - 2.5.5.5. Үнэт цаасны танилцуулга, түүнд тусгагдсан мэдээлэл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, бусад холбогдох хууль журамд нийцэж буй эсэх, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх.
- 2.6. Барьцаат үнэт цаас гаргагчийн хувьд бүртгүүлэх ажиллагааны бэлтгэл шатанд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 2.6.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан, Хорооноос зөвшөөрөл авсан хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчтай гэрээ байгуулж, томилсон байх;
 - 2.6.2. Хорооноос эрх авсан хөндлөнгийн аудитын үйл ажиллагаа эрхлэх эрхтэй этгээдтэй гэрээ байгуулан, дараах агуулга бүхий дүгнэлт гаргуулсан байх. Үүнд:
 - 2.6.2.1. Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргах;
 - 2.6.2.2. Үнэт цаас гаргагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /цаашид “СТОУС” гэх/-д нийцэж байгаа эсэх;
 - 2.6.2.3. Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн тайлангийн мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх.

- 2.6.3. Барьцаат үнэт цаас гаргагч нь Хороонд бүртгэлтэй хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрхтэй этгээдтэй гэрээ байгуулан, дараах агуулга бүхий дүгнэлтийг гаргуулсан байх. Үүнд:
- 2.6.3.1. Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх;
 - 2.6.3.2. Үнэт цаас гаргагчийн дүрэм, үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах журам, зааврууд нь хууль тогтоомжид нийцсэн эсэх;
 - 2.6.3.3. Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдтэй буюу энэхүү журмын 2.4, 2.6.1, 2.6.2-д заасан этгээдтэй байгуулсан гэрээ болон үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаатай холбогдох бусадтай байгуулсан чухал ач холбогдолтой гэрээ хэлцэл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх;
 - 2.6.3.4. Үнэт цаас гаргагчийн сүүлийн 1 жилийн хугацаанд хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүд нь хуульд заасан журмын дагуу байгуулагдсан эсэх;
 - 2.6.3.5. Үнэт цаасны танилцуулга болон түүнд тусгагдсан мэдээлэл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, бусад холбогдох хууль, журамд нийцэж буй эсэх, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх;
 - 2.6.3.6. Үнэт цаас гаргагч, түүний үүсгэн байгуулагч, ТУЗ, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд нь ХБҮЦ гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх;
 - 2.6.3.7. ХБҮЦ гаргагч болон түүний үнэт цаасанд гуравдагч этгээдээс баталгаа гаргах тохиолдолд уг этгээдэд тийнхүү баталгаа гаргахыг хориглосон хууль эрх зүйн хязгаарлалт байгаа эсэх;
 - 2.6.3.8. Хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч, үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч, түүний хувьцааны 10-аас дээш хувийг дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт эзэмшигч, ТУЗ-ийн гишүүд, баталгаа гаргагч нь хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэлтэй эсэх.
- 2.7. Энэхүү журмын 2.4, 2.5.2-2.5.5; 2.6.1-2.6.3-д заасан этгээдтэй байгуулсан гэрээнд талуудын хүлээх хариуцлагыг тодорхой заасан байх бөгөөд үнэт цаас гаргагч нь дүгнэлт гаргахад шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг бүрэн ирүүлэх үүрэгтэй болохыг, үйлчилгээ үзүүлж буй этгээд нь дүгнэлт гаргахын тулд холбогдох бичиг баримтыг бүрэн судалж, зохих стандартын дагуу үйл ажиллагаа явуулах, гаргасан дүгнэлтийнхээ хариуцлагыг бүрэн хүлээх тухайгаа тус тус тусгасан байна.
- 2.8. Бирж нь ХБҮЦ гаргагчийн гаргаж буй үнэт цаасны төрөл, нөхцөл, санал болгож буй цар хүрээ зэргээс хамааран үнэт цаас гаргагч болон түүнд баталгаа гаргагч этгээдийг Хороонд бүртгэлтэй үнэлгээний байгууллагаар хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийлгэхийг шаардаж болно.
- 2.9. Бирж нь шаардлагатай гэж үзвэл барьцаат ба баталгаат үнэт цаасанд зээлийн зэрэглэл тогтоолгож болох ба тухайн тохиолдолд Хорооны журмын 2.6-д заасан нөхцөл шаардлагыг хангасан байна.

3 дугаар зүйл. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгүүлэх хүсэлт гаргах

- 3.1. ХБҮЦ гаргагч нь Хорооноос ХБҮЦ-ыг бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш уг үнэт цаасыг Биржид бүртгүүлэх тухай хүсэлтийг гаргана.
- 3.2. ХБҮЦ бүртгүүлэхдээ Хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 2.8 болон 5.10-д заасан баримт, материалуудаас гадна дараах бичиг баримтыг Биржид хэвлэмэл болон цахим хэлбэрээр ирүүлнэ. Үүнд:
 - 3.2.1 ХБҮЦ бүртгүүлэх өргөдөл /Хавсралт 1-д заасан Маягт 1-ийн дагуу/;
 - 3.2.2 ХБҮЦ гаргагч болон үүсгэн байгуулагчийн мэдэгдэл /Хавсралт 1-д заасан Маягт 2-ын дагуу/;
 - 3.2.3 ХБҮЦ-ыг олон нийтэд санал болгон худалдах үйл ажиллагаанд андеррайтер оролцох тохиолдолд андеррайтерийн мэдэгдэл /Хавсралт 1, Маягт 3/;
 - 3.2.4 ХБҮЦ гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;
 - 3.2.5 ХБҮЦ-ыг бүртгэх, олон нийтэд санал болгохыг зөвшөөрсөн Хорооны тогтоолын хуулбар;
 - 3.2.6 Хороонд бүртгүүлж, баталгаажуулсан ХБҮЦ-ны танилцуулга;
 - 3.2.7 Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
 - 3.2.8 Энэхүү журмын гуравдугаар бүлэгт заасан шалгуур, шаардлагыг хангаж байгаа болохыг нотлох баримт, материал;
 - 3.2.9 Баталгаат үнэт цаас гаргагчийн хувьд энэхүү журмын 2.4, 2.5.2-2.5.5-д, харин барьцаат үнэт цаас гаргагчийн хувьд энэхүү журмын 2.4, 2.6.1-2.6.3-д заасан этгээдтэй байгуулсан гэрээний хуулбар;
 - 3.2.10 Баталгаат үнэт цаас гаргагчийн хувьд энэхүү журмын 2.5.5-д заасан, харин барьцаат үнэт гаргагчийн хувьд 2.6.2, 2.6.3-д заасан аудит ба хууль зүйн дүгнэлт;
 - 3.2.11 Шаардлагатай тохиолдолд энэхүү журмын 2.8, 2.9-д заасан мэргэжлийн этгээдийн үнэлгээ болон зэрэглэл тогтоосон тайлан, дүгнэлт;
 - 3.2.12 ХБҮЦ гаргагчийн дараах ажиллагааг зохицуулсан багц дүрэм журмууд:
 - 3.2.12.1. ТУЗ-ийн үйл ажиллагааны тухай;
 - 3.2.12.2. Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч зэргийг сонгох, солих тухай;
 - 3.2.12.3. Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх тухай;
 - 3.2.12.4. Эрсдлийн удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх тухай;
 - 3.2.12.5. Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, хөрөнгийг багцаас хасах тухай;
 - 3.2.12.6. Үндсэн үйл ажиллагааны бусад дүрэм, журмууд.
 - 3.2.13 Үнэт цаас, түүний эргэн төлөлтөнд хөндлөнгийн этгээд баталгаа гаргаж байгаа тохиолдолд тус этгээдийн үйл ажиллагаа ба санхүүгийн мэдээлэл, үнэт цаас гаргагч ба баталгаа гаргагчийн хооронд харилцан ойлголцсон талаарх баримт бичиг, баталгааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох бусад материал;
 - 3.2.14 ХБҮЦ-ны хөрөнгийн багцыг 10-аас доош тооны зээлдэгч бүрдүүлж байгаа, эсхүл зээлдэгчийн зээлийн үнийн дүн нь нийт хөрөнгийн багцын үнийн

дүнгийн 10 ба түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа тохиолдолд уг зээлдэгчдийн талаарх мэдээлэл;

3.2.15 Энэ журмын 11.2.1 -д заасан өргөдөл хүлээн авах, хянах үйлчилгээний хөлс төлсөн баримт;

3.2.16 Биржээс шаардлагатай гэж үзсэн бусад бичиг баримт.

3.3. ХБҮЦ-ыг бүртгэх эсэх тухай Биржийн шийдвэр гарахаас өмнө Хороонд хүргүүлсэн болон энэхүү журмын хүрээнд Биржид ирүүлсэн материалд өөрчлөлт орсон, материал ирүүлснээс хойш үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа болон түүний үйл ажиллагаа явуулж буй зах зээлд хөрөнгө оруулагчийн шийдвэрт нөлөө үзүүлэхүйц үйл явдал болсон бол тухай бүр уг мэдээлэл, баримт бичгийг Биржид ирүүлнэ.

3.4. ХБҮЦ бүртгүүлэхээр болон бүртгүүлснээс хойш ирүүлэх баримт, бичгийг Монгол хэл дээр үйлдэнэ.

4 дүгээр зүйл. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулгын агуулга, хэлбэр

4.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан болон Хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 2.9-д заасан мэдээллийг баталгаат үнэт цаас гаргагч, мөн журмын 5.13-т заасан мэдээллийг барьцаат үнэт цаас гаргагч нь тус тусын үнэт цаасны танилцуулгад тусгах ба Биржийн журмын хүрээнд дараах мэдээллийг нэмэлтээр үнэт цаасны танилцуулгад тусгасан байна. Үүнд:

4.1.1 ХБҮЦ-ыг олон нийтэд санал болгон худалдах ба хуваарилах нөхцөл, хэсэгчлэн худалдах тохиолдолд санал болгох үе шатууд;

4.1.2 Үнэт цаасыг хэд хэдэн ангиллаар худалдах тохиолдолд ангилал тус бүрийн эрсдэл, өгөөж, багцыг бүрдүүлж буй хөрөнгө, тухайн ангиллын үнэт цаасны арилжигдах үнэ ба нэрлэсэн үнэ, тоо ширхэгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл;

4.1.3 Энэхүү журмын 3.3-т заасан мэдээлэл нь үнэт цаасны танилцуулгад материаллаг өөрчлөлт оруулахаар бол уг мэдээлэл;

4.1.4 Танилцуулгын эхний хуудсанд дараах анхааруулгыг тодоор бичсэн байна. Үүнд:

“Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын хөрөнгийн бирж бүртгэсэн нь уг үнэт цаасны эрсдэлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй. Энэхүү үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч Таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, үнэт цаасны танилцуулга, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.”

5 дугаар зүйл. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Биржид бүртгэх, бүртгэхээс татгалзах

5.1. ХБҮЦ гаргагч нь энэ журамд заасны дагуу өргөдөл болон хавсаргах бичиг баримтыг зохих шаардлагын дагуу бүрдүүлсэн эсэх, журмаар тогтоосон шалгуур, шаардлагыг хангаж буй эсэх талаар Биржийн үнэт цаасны бүртгэл хариуцсан алба, нэгж нь бүртгэлийн шалгалт хийх бөгөөд уг шалгалтын тайлан, дүгнэлтийг үндэслэн Биржийн Гүйцэтгэх захирал /цаашид Гүйцэтгэх захирал гэх/ ХБҮЦ-ыг бүртгэх, эсхүл бүртгэхээс татгалзах тухай шийдвэрийг гаргана.

- 5.2. Бирж ХБҮЦ бүртгүүлэх өргөдлийг хянан шалгах ажиллагааг зохион байгуулах болон бүртгэх, бүртгэхээс татгалзах тухай шийдвэр гаргахдаа Биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 8 дугаар зүйлийг баримтална.
- 5.3. Бирж ХБҮЦ-ыг бүртгэх шийдвэр гаргасан тохиолдолд Гүйцэтгэх захирлын тушаалыг үнэт цаас гаргагчид хүргүүлж, бүртгэлийн гэрээ байгуулах ба бүртгэсэн тухай Гүйцэтгэх захирлын тушаалын хуулбар, холбогдох мэдэгдлийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад хүргүүлнэ.
- 5.4. Биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д зааснаас гадна дараах тохиолдлуудад ХБҮЦ-ыг бүртгэхээс татгалзана. Үүнд:
 - 5.4.1 ХБҮЦ гаргагч болон үнэт цаас нь энэхүү журмаар тогтоосон шалгуур, шаардлагыг хангаагүй;
 - 5.4.2 Үнэт цаас бүртгүүлэх тухай өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичигт хуурамч мэдээлэл агуулагдсан нь тогтоогдсон.
- 5.5. Үнэт цаасыг бүртгэхээс татгалзсан тохиолдолд энэ талаар үндэслэл бүхий тайлбар, мэдэгдлийг Гүйцэтгэх захирлын тушаалын хамт хүсэлт гаргагчид хүргүүлнэ.
- 5.6. Үнэт цаас гаргагч нь Биржид ирүүлсэн танилцуулга, түүнд хавсаргасан бичиг баримт, хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт зэрэг бүртгүүлэхтэй холбоотой бүхий л бичиг баримтыг Биржийн бүртгэлд бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш арван жилийн хугацаанд өөр дээрээ хадгална.
- 5.7. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасыг бүртгэхээс татгалзсан тухай Биржийн шийдвэрийг эс зөвшөөрвөл Хороонд холбогдох журмын дагуу гомдол гаргах эрхтэй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ШАЛГУУР, ШААРДЛАГА

6 дугаар зүйл. Ерөнхий шалгуур, шаардлага

- 6.1. ХБҮЦ гаргагч, түүний үнэт цаас болон ХБҮЦ-ны харилцаанд оролцогч этгээд нь Биржид бүртгүүлэхэд болон бүртгэлтэй байх хугацаанд холбогдох хууль, Хорооны журам ба энэ журамд заасан шалгуур, шаардлагыг тогтмол хангаж ажиллана.
- 6.2. ХБҮЦ гаргагч нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам болон өөрийн эрх зүйн баримт бичгийг бүрэн дагаж мөрдөнө.
- 6.3. ХБҮЦ гаргагч, түүний үүсгэн байгуулагч, ТУЗ, гүйцэтгэх удирдлага, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид болон ХБҮЦ-ны харилцаанд оролцогч бусад этгээд нь үнэнч шударга, мэргэжлийн ёс зүйтэй ажиллана.
- 6.4. ХБҮЦ гаргагч, ХБҮЦ-ны харилцаанд оролцогч этгээдийн эрх бүхий албан тушаалтнууд нь тухайн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай мэдлэг, туршлагатай байна.
- 6.5. Бирж ХБҮЦ-ыг худалдан авагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх, тэдэнд эрсдэл учрах магадлалтай гэж үзвэл хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгө, түүний эрхийг барьцаагаар баталгаажуулахыг, зохих эд хөрөнгө ба этгээдийн үйл ажиллагааг даатгалд хамруулахыг, эсхүл гуравдагч хөндлөнгийн этгээдээр баталгаа гаргуулахыг ХБҮЦ гаргагчаас тус тус шаардаж болно.
- 6.6. ХБҮЦ-нд зээлийн зэрэглэл тогтоолгосон тохиолдолд Хорооны журмын 2.6 дахь нөхцөл шаардлагыг хангаж ажиллана.

7 дугаар зүйл. ХБҮЦ гаргагч болон үнэт цаасанд тавигдах шалгуур, шаардлага

7.1. Биржийн бүртгэлд ХБҮЦ бүртгүүлэх хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 7.1.1 Баталгаат үнэт цаас гаргагчийн хувьд ТЗК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн зохих шаардлага болон Хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 2 болон 3-т заасан, харин барьцаат үнэт цаас гаргагчийн хувьд тус журмын 5-д заасан шаардлага, нөхцлийг хангасан байх;
- 7.1.2 Энэхүү журмын 2.5 болон 2.6-д заасан бэлтгэл ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан байх;
- 7.1.3 ХБҮЦ-ны танилцуулгыг боловсруулж, Хороонд бүртгүүлэн, баталгаажуулсан байх;
- 7.1.4 Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх, хэрэв мөрддөггүй бол тайлбар гаргах;
- 7.1.5 ХБҮЦ гаргагч нь өөрөө, эсхүл бусдаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх замаар ХБҮЦ-тай холбогдсон харилцаанд ашиглагдах энэхүү журмын 3.2.12-д заасан зохих дүрэм, журмуудыг батлан, дагаж мөрддөг байх.

7.2. ХБҮЦ нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

- 7.2.1 ХБҮЦ нь Хорооны нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдсэн байх;
- 7.2.2 ХБҮЦ-ыг хэд хэдэн ангилал /транч/-тай гаргах тохиолдолд тухайн ангиллын үнэт цаас нь ижил нөхцөл, хугацаа, хүү, зээлжих зэрэглэл, чанартай байх;
- 7.2.3 ХБҮЦ-ны хувьд Монгол Улсын Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл, барьцаат үнэт цаасны хувьд тус хуулийн 32.1 дүгээр зүйл болон Хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 7-д заасан барьцаат үнэт цаасны хөрөнгийн багц, түүний үндсэн болон нэмэлт хөрөнгөнд тавигдах шаардлагыг хангасан байх;
- 7.2.4 Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын барьцааны зүйл нь Хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 7.7-д заасан шаардлагыг хангасан байх;
- 7.2.5 ХБҮЦ нь чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй байх.

8 дугаар зүйл. Шалгуур, шаардлагаас чөлөөлөх буюу хөнгөлөх

8.1. ХБҮЦ гаргагч нь энэхүү журмаар тогтоосон нөхцөл, шаардлага, шалгуураас чөлөөлүүлэх буюу хөнгөлүүлэх тухай үндэслэл бүхий хүсэлтээ Биржид гаргаж болно.

8.2. Биржээс тогтоосон энэхүү журмын гуравдугаар бүлэгт заасан шалгуур шаардлагаас дараах тохиолдолд хөнгөлөлт эдлүүлэх буюу чөлөөлж болно. Үүнд:

- 8.2.1 Улсын эдийн засгийн хөгжилд өндөр ач холбогдол бүхий төсөл хэрэгжүүлэгч, эсхүл үүрэг гүйцэтгэгч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд ХБҮЦ гаргасан;
- 8.2.2 ХБҮЦ-нд гуравдагч этгээд бүхэлд нь баталгаа гаргасан;

8.2.3 Тухайн үнэт цаасыг зөвхөн мэргэжлийн хөрөнгө оруулагч нарт санал болгон худалдах, уг ХБҮЦ нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж, эрэлт ихээр үүсгэх бүрэн боломжтой гэж Бирж үзсэн.

8.3. Энэхүү журмын 8.2-т заасан асуудлыг Биржийн Гүйцэтгэх захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БҮРТГЭЛТЭЙ БАЙХ ХУГАЦААНД БИЕЛҮҮЛЭХ ҮҮРЭГ

9.1. ХБҮЦ гаргагч нь Монгол Улсын үнэт цаасны зах зээл дээр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, заавар, Биржтэй байгуулсан гэрээ, үнэт цаас гаргагчийн мэдэгдэлд туссан хөрөнгө оруулагчдын болон эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн үүргээ бүртгэлтэй байх хугацаанд бүрэн биелүүлж ажиллана.

9.2. ХБҮЦ гаргагч нь бүртгэлтэй байх хугацаандаа Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хорооны холбогдох журам болон энэхүү журамд заасан шалгуур, шаардлагыг тогтмол хангаж ажиллана.

9.3. ХБҮЦ гаргагч нь үндсэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхээр баталсан өөрийн дүрэм, журмыг нягт баримталж ажиллах ба уг эрх зүйн баримт бичгүүдэд хууль, журмаар зөвшөөрсөн этгээдийн шийдвэрээр өөрчлөлт оруулна.

9.4. Санхүүгийн тайлан тэнцлийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/-д нийцүүлэн үнэн зөв гаргаж, зөвшөөрөгдсөн аудитын байгууллагаар баталгаажуулах ба Хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 8 дугаар зүйлд заасны дагуу аудитын хяналт шалгалтыг тогтмол хийлгэнэ.

9.5. ХБҮЦ гаргагч нь мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, үнэт цаас эзэмшигчид, эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий Биржтэй харилцах этгээдтэй байх ба энэхүү үүргээ өөрөө, эсхүл гуравдагч этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

9.6. ХБҮЦ гаргагч нь үнэт цаас эзэмшигч, хөрөнгө оруулагч нарт мэдээлэл түгээх, тэдний эрхийг хэрэгжүүлэх тал дээр ижил, тэгш хандах зарчмыг баримтлах ба хөрөнгө оруулагчидтай харилцах, хууль тогтоомжийн дагуу тогтмол мэдээ, мэдээллийг хүргэх нөхцлийг бүрэн хангаж ажиллана.

9.7. ХБҮЦ гаргагч нь дараах болон ханшид нөлөөлөх бусад мэдээллийг холбогдох хууль тогтоомж, Хорооны журам, энэхүү журамд заасан хугацаанд Биржид мэдэгдэх ба өөрийн болон Биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд түгээх үүрэгтэй. Үүнд:

9.7.1 Тогтоосон хугацаанд толилуулах шаардлагатай мэдээллүүд:

9.7.1.1. Жилийн эцсийн болон хагас жилийн санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд;

9.7.1.2. Жилийн үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлан /үнэт цаасанд гуравдагч этгээд баталгаа гаргасан тохиолдолд баталгаа гаргагчийн тайлан/-г дараа оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор;

9.7.1.3. Багцын хөрөнгө, мөнгөн урсгалын хөдөлгөөн, үнэт цаасны төлбөр, тооцоотой холбоотой Хороо болон хөрөнгө оруулагчдад хүргүүлсэн улирал тутмын тайлан, мэдээллийг дараа улирлын 20-ны өдрийн дотор;

9.7.2 Холбогдох шийдвэр, өөрчлөлт гарсан, тухайн үйл явдал болсон даруйд буюу ажлын 3 хоногт багтаан ирүүлэх мэдээллүүд:

- 9.7.2.1. Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийн мэдээлэл, төлбөрийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсэх, хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд түүний шалтгаан, авах арга хэмжээний тухай;
- 9.7.2.2. Хөрөнгийн багц, барьцааны зүйлийн нийт үнийн дүнгийн 10 хувь буюу түүнээс дээш хэмжээтэй өөрчлөлт орох;
- 9.7.2.3. Бүртгэлтэй үнэт цаастай холбоотой аливаа өөрчлөлт (ХБҮЦ-ны нөхцөл, төлбөрийн хуваарь өөрчлөгдөх, гаргасан ХБҮЦ-ыг хугацаанаас нь өмнө буцаан дуудах, нэмэлт үнэт цаас гаргах гэх мэт)-ийн талаарх мэдээлэл;
- 9.7.2.4. Бүртгэлтэй ХБҮЦ-ны 10 хувиас дээш үнийн дүн бүхий буцаан дуудсан, эргүүлэн худалдаж авсан үнэт цаасны мэдээлэл, цаашид 5 хувиар өөрчлөгдөх тутамд;
- 9.7.2.5. ХБҮЦ гаргагчийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, дүрэм, журам, хяналтын багц эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, холбоо барих хаяг, байршил, утас зэрэгт өөрчлөлт орох;
- 9.7.2.6. Үнэт цаас эзэмшигчдийн эрхэд өөрчлөлт оруулах, компанийн дүрэм, холбогдох гэрээ, журамд тэдгээрийн эрх ашигт нөлөөлөх нэмэлт өөрчлөлтийг тусгах;
- 9.7.2.7. Үнэт цаас эзэмшигчдийн хурал зохион байгуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд хурал хуралдуулах тухай шийдвэр, хурлын мэдэгдэл, хурлаас гарсан шийдвэр;
- 9.7.2.8. Барьцаат үнэт цаас гаргагчийн хувьд шинээр үнэт цаас гаргахтай холбоотойгоор барьцаа, баталгаа гаргах;
- 9.7.2.9. ХБҮЦ-ны харилцаанд оролцогч этгээд солигдох, бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөх, түүнтэй байгуулсан гэрээнд өөрчлөлт орох;
- 9.7.2.10. Төлбөрийн чадваргүй болох, эсхүл бусад байдлаар шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэнтэй холбоотой мэдээлэл;
- 9.7.2.11. Эрх бүхий байгууллагаас ХБҮЦ гаргагчид авсан арга хэмжээний тухай;
- 9.7.2.12. Үнэт цаас эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын шийдвэр, ХБҮЦ гаргагчийн үйл ажиллагаа, үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх, зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээлэлд хамаарах бусад мэдээллүүд.

ТАВДУГААР БҮЛЭГ. ХБҮЦ-НЫ АРИЛЖААГ ЗОГСООХ, БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

10.1. ХБҮЦ-ны арилжааг зогсоохдоо Хорооны Улсын байцаагчийн шийдвэрийг үндэслэх ба дараах тохиолдлуудад арилжааг түр зогсоох тухай саналыг Хороонд хүргүүлнэ.

Үүнд:

- 10.1.1 ХБҮЦ гаргагч нь тогтмол биелүүлэх үүргээ биелүүлээгүйгээс хөрөнгө оруулагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүссэн;
- 10.1.2 ХБҮЦ-ны харилцаанд оролцогч мэргэжлийн этгээдүүд нь дампуурч, татан буугдсан, эсвэл татан буугдах, дампуурах нөхцөл байдал бий болсон, тэдгээрийн үндсэн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл түдгэлзсэн, цуцлагдсаны улмаас холбогдох гэрээний эрх, үүргийг эрх бүхий өөр этгээдэд шилжүүлэх шаардлага үүссэн;
- 10.1.3 ХБҮЦ-ны үндсэн болон хүүгийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй;

- 10.1.4 Хөрөнгө оруулагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх бусад нөхцөл байдал.
- 10.2. ХБҮЦ-ны арилжааг сэргээх тухай мэдэгдлийг дараах тохиолдлуудад Хороонд хүргүүлнэ. Үүнд:
- 10.2.1 Үнэт цаас гаргагч нь гаргасан зөрчлөө арилгасан тухайгаа мэдэгдсэн, эсхүл Биржээс уг зөрчлийг арилсан гэж тогтоосон;
 - 10.2.2 Зохицуулах эрх бүхий байгууллага, шүүх хяналтын байгууллагаас үнэт цаас гаргагчид авсан арга хэмжээг үндэслэлгүй гэж үзсэн;
 - 10.2.3 Хууль тогтоомж, дүрэм, журамд заасан бусад үндэслэл.
- 10.3. ХБҮЦ-ийг үнэт цаас гаргагчийн хүсэлтээр болон Биржийн санаачлагаар дараах тохиолдлуудад бүртгэлээс хасах ба хасах шийдвэрийг Биржийн гүйцэтгэх захирал гаргана. Үүнд:
- 10.3.1 Үнэт цаас гаргагчийг татан буулгах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр гарсан;
 - 10.3.2 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан ТЗК татан буугдах нөхцөл бүрдсэн;
 - 10.3.3 ХБҮЦ-тай холбоотой үүрэг дуусгавар болсон буюу үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөр бүрэн төлөгдөж дууссан;
 - 10.3.4 Хороо болон Биржээс тогтоосон шалгуур, шаардлагыг биелүүлж чадахгүй болсон нь тогтоогдсон;
 - 10.3.5 Бүртгэлтэй байх хугацаанд тогтмол биелүүлэх үүрэг болон хууль, дүрэм, журам, гэрээгээр хүлээсэн үүргээ 2 ба түүнээс дээш удаа зөрчсөн;
 - 10.3.6 Үнэт цаасны арилжааг зогсоосноос хойш хагас жилээс дээш хугацаанд арилжаа сэргээгүй буюу арилжааг зогсоох нөхцөл шалтгаан нь арилаагүй;
 - 10.3.7 Хууль, журамд заасан бусад үндэслэлээр.
- 10.4. Энэхүү журмын 10.3-т заасан шийдвэрийг гаргахтай холбоотойгоор үнэт цаас гаргагч нь дараах баримт, бичгийг Биржид бүрдүүлэн ирүүлнэ. Үүнд:
- 10.4.1 ХБҮЦ-ыг бүртгэлээс хасуулах тухай холбогдох этгээдийн шийдвэр (үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, эрх бүхий төр, захиргааны байгууллагын шийдвэр гэх мэт) ;
 - 10.4.2 Бүртгэлээс хасагдах нөхцөл, шаардлага буюу энэхүү журмын 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалтын тохиолдлууд бүрдсэн болохыг нотлох баримт, зохих байгууллага, этгээдийн дүгнэлт, тодорхойлолт, шийдвэр;
 - 10.4.3 Бусад шаардлагатай бичиг баримт.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

- 11.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49.3-т заасны дагуу Бирж нь ХБҮЦ-ыг бүртгүүлэх өргөдлийг хянан шийдвэрлэж, үнэт цаасыг Биржийн бүртгэлд бүртгэх, нийтэд санал болгон худалдах, худалдан авахтай холбоотой гэрээ, хэлцэл байгуулах нөхцлийг бүрдүүлэх, тус үнэт цаасны арилжааг зохион байгуулах үндсэн чиг үүргийнхээ хүрээнд үнэт цаас гаргагчид үзүүлж байгаа үйлчилгээнийхээ хөлсийг тогтоон авах эрхтэй.
- 11.2. ХБҮЦ гаргагчид Биржээс үзүүлэх үйлчилгээний хөлс нь дараах төрөлтэй байна. Үүнд:
- 11.2.1 Бүртгүүлэх өргөдөл хүлээн авч хянах үйлчилгээний хөлс – 2,000,000 /хоёр сая/ төгрөг;
 - 11.2.2 ХБҮЦ бүртгэх үйлчилгээний хөлс – Нийт бүртгүүлсэн үнэт цаасны үнийн дүнгийн 0.05%.

- 11.3. Үнэт цаас гаргагч нь өргөдлийг хүлээн авч хянах үйлчилгээний хөлсийг Биржид үнэт цаас бүртгүүлэх тухай өргөдөл гаргахдаа буцаан олгогдохгүй нөхцөлтэйгөөр төлж, энэ тухай баримтыг өргөдөлдөө хавсаргана.
- 11.4. ХБҮЦ бүртгэх үйлчилгээний хөлсний хэмжээг тухайн үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлбэл зохих мөнгөн хөрөнгөөс тооцох ба энэхүү журмын 11.2.2-д заасан хэмжээгээр тооцож, анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор Биржийн дансанд шилжүүлнэ.
- 11.5. ХБҮЦ-ны бүртгэх үйлчилгээний хөлсний хэмжээ 2,500,000 /хоёр сая таван зуун мянга/ төгрөгөөс багагүй байна.

ДОЛООДУГААР БҮЛЭГ. ХАРИУЦЛАГА

- 12.1. ХБҮЦ гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан болон хамтран ажиллаж буй мэргэжлийн байгууллага нь энэхүү журам болон бусад холбогдох дүрэм, журмыг зөрчсөн, эсхүл хэрэгжүүлээгүй тохиолдолд энэ журам болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 12.2. ХБҮЦ гаргагч нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг хэрхэн мөрдөж байгаад энэхүү журмын 13.2-т заасны дагуу Биржээс хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар үнэт цаас гаргагч, түүний холбогдох этгээдэд шаардлага хүргүүлэн, журам болон гэрээний дагуу хариуцлага ногдуулж болно.
- 12.3. ХБҮЦ гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан болон холбогдох этгээдэд дараах хэлбэрийн хариуцлагыг хамтад нь, эсхүл тус тусад нь тооцно.
 - 12.3.1 Сануулах;
 - 12.3.2 Гэрээний хариуцлага ногдуулах;
 - 12.3.3 ХБҮЦ-ны арилжааг зогсоох тухай мэдэгдэл Хороонд хүргүүлэх;
 - 12.3.4 ХБҮЦ-ыг бүртгэлээс хасах.
- 12.4. Ногдуулах хариуцлагын хэлбэрийг сонгохдоо Бирж нь ХБҮЦ гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан болон холбогдох этгээдийн гаргасан зөрчлийн шинж чанар, гэм буруутай байдлыг харгалзаж үзнэ.
- 12.5. ХБҮЦ-ны танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд оролцсон этгээд өөрийн гүйцэтгэсэн ажилтай холбоотойгоор бусдад учруулсан хохирлыг тус бүртгээ хариуцна.

НАЙМДУГААР БҮЛЭГ. БУСАД

- 13.1. ХБҮЦ гаргагч нь Биржээс үнэт цаас гаргагчтай холбоотой буюу Биржид бүртгэлтэй үнэт цаастай холбоотойгоор гаргасан аливаа шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор Хороонд гомдол гаргаж болно.
- 13.2. Биржийн хяналт шалгалт хариуцсан алба, нэгж нь ХБҮЦ гаргагчийн үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, журам, заавар, гэрээний үүргийн биелэлтэд холбогдох журамд заасны дагуу зайны хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд газар дээрх шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулна.

БҮРТГЭЛИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ**/Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгүүлэх-д/**Хэнд: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК,
Бүртгэлийн алба

Огноо:.....

Эрхэм Танаа,

Бид [Үнэт цаас гаргагч хуулийн этгээд, түүнийг төлөөлж] энэхүү маягтын 3-т тусгасан үнэт цаасыг “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК /цаашид “Бирж” гэх/-ийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу бүртгүүлж, арилжаалах зөвшөөрөл авахаар энэхүү өргөдлийг гаргаж байна.

1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ					
Хуулийн этгээдийн нэр					
Хуулийн этгээдийн хэлбэр					
Үүсгэн байгуулагдсан огноо					
Улсын бүртгэлийн дугаар					
Регистерийн дугаар					
Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрийн дугаар, огноо /нотлох баримтыг хавсаргана/					
Хаяг байршил		Аймаг/Хот			
		Сум/Дүүрэг			
		Баг/Хороо			
		Гудамж/Байр			
		Тоот			
Холбоо барих утас					
Албан ёсны цахим хуудас болон цахим шуудангийн хаяг					
Биржтэй харилцах этгээд /үнэт цаас хариуцсан ажилтан/-ийн нэр, албан тушаал, холбоо барих утас, цахим шуудангийн хаяг					
Өөрийн хөрөнгийн болон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ					
ҮЦГ-ийн эрх бүхий албан тушаалтны мэдээлэл					
Албан тушаал	Овог нэр	Харьяалал	Регистерийн дугаар	Боловсрол мэргэжил	Ажлын туршлага
ТУЗ-ийн дарга, гишүүд					

/ердийн, хараат бус/					
Гүйцэтгэх удирдлага г.м					
<i>Тэмдэглэл: Дээрх мэдээллийг ТУЗ-ийн гишүүн, ЭБАТ бүрээр бичнэ.</i>					
2. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ					
Хуулийн этгээдийн нэр	Монгол Англи				
Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр
Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани <input type="checkbox"/> Хязгаардагдмал хариуцлагатай компани				
Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай				
Улсын бүртгэлийн дугаар					
Регистерийн дугаар					
Үйл ажиллагааны үндсэн чиглэл					
Хаяг байршил	Аймаг/Хот				
	Сум/Дүүрэг				
	Баг/Хороо				
	Гудамж/Байр				
	Тоот				
Холбоо барих утас					
Албан ёсны цахим хуудас болон цахим шуудангийн хаяг					
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн холбоотой этгээдийн мэдээлэл					
Компанийн тухай хуулийн 6.14-д заасан компанийн нэгдлийн оролцогч эсэх?	<input type="checkbox"/> Тийм		<input type="checkbox"/> Үгүй		
Тийм бол компанийн нэгдлийн бүтэц зохион байгуулалт, хувь эзэмшлийн байдал, хамаарал бүхий бусад хуулийн этгээдийн талаарх мэдээллийг бичнэ үү.					
Үйл ажиллагааны цэвэр ашиг	₮				
Үнэт цаасжуулах хөрөнгийг ТЗК-д шилжүүлсэн гэрээний огноо, дугаар /гэрээний хувийг хавсаргана/					
3. ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ					
<i>Үнэт цаас нь хэд хэдэн ангилалтай бол тус бүрээр мэдээллийг оруулна.</i>					
Үнэт цаасны нэр					
Үнэт цаасны төрөл					
Үнэт цаас бүртгүүлэх арга					
Үнэт цаасны ангилал					
Үнэт цаасны тоо ширхэг, нэрлэсэн үнэ, нийт үнийн дүн					
Үнэт цаасны хугацаа, хүү, хүү тооцох аргачлал, төлбөрийн хуваарь					
Үнэт цаасны нөхцөл /хөрвөх, хувьсах, тогтмол хүү, хугацаанаас өмнө буцаан татах, эргүүлэн худалдаж авах нөхцөл г.м/					

Үнэт цаасны нийтэд санал болгох хувь хэмжээ, хэлбэр, үнэ	
Үнэт цаас гаргах замаар нийтээс татан төвлөрүүлэхээр тооцсон хөрөнгийн хэмжээ	
Үнэт цаасыг баталгаажуулж байгаа хөрөнгийн багцын талаарх мэдээлэл /хөрөнгийн төрөл, тоо хэмжээ, үнийн дүн, жигнэсэн дундаж хүү, жигнэсэн дундаж хугацаа/	
Үнэт цаасны барьцаа, баталгааны талаарх мэдээлэл	
Төлбөрийн эргэн төлөлтийг сайжруулах этгээд, гадаад, дотоод эх үүсвэрийн тухай	
Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар зээлжих эрхийн үнэлгээ, санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоолгосон эсэх тухай мэдээлэл	
Үнэт цаасыг нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн хугацаа	
4. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ, БАГЦЫН БҮРТГЭЛИЙГ ХЯНАГЧ, ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧ, БАТАЛГАА ГАРГАГЧ ЭТГЭЭДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	
<i>Мэдээллийг холбогдох этгээд тус бүрээр бичнэ.</i>	
Хуулийн этгээдийн нэр	Монгол Англи
Үүсгэн байгуулагдсан огноо	Он Сар Өдөр
Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани <input type="checkbox"/> Хязгаардагдмал хариуцлагатай компани
Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай
Улсын бүртгэлийн дугаар	
Регистрийн дугаар	
Үйл ажиллагааны чиглэл	
Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрийн дугаар, огноо /нотлох баримтыг хавсаргана/	
Харилцах	Банкны нэр
	Дансны дугаар
	Валютын төрөл
	Үлдэгдэл
Хадгаламж	Банкны нэр
	Дансны дугаар
	Валютын төрөл
	Үлдэгдэл
Хаяг байршил	Аймаг/Хот
	Сум/Дүүрэг
	Баг/Хороо
	Гудамж/Байр
	Тоот
	Холбоо барих утас

Албан ёсны цахим хуудас болон цахим шуудангийн хаяг	
ҮЦГ-тай байгуулсан гэрээний дугаар, огноо /гэрээний хувийг хавсаргана/	
5. ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БУСАД ЭТГЭЭД /аудит, рейтинг, андеррайтер, хуулийн байгууллага/-ИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	
Хуулийн этгээдийн нэр	Монгол Англи
Үүсгэн байгуулагдсан огноо	Он Сар Өдөр
Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани <input type="checkbox"/> Хязгаардагдмал хариуцлагатай компани
Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай
Улсын бүртгэлийн дугаар	
Регистрийн дугаар	
Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрийн дугаар, огноо /нотлох баримтыг хавсаргана/	
Хаяг байршил	Аймаг/Хот
	Сум/Дүүрэг
	Баг/Хороо
	Гудамж/Байр
	Тоот
Холбоо барих утас	
Албан ёсны цахим хуудас болон цахим шуудангийн хаяг	

Өргөдөл гаргасан:

Овог, нэр:

Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
"....."К-ийн
ТУЗ-ийн дарга

Албан тушаал: Үүсгэн байгуулагч
"....."К-ийн
ТУЗ-ийн дарга

Гарын үсэг:

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

Овог, нэр:

Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
"....."К-ийн
ТУЗ-ийн гишүүн
.....

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
"....."К-ийн
ТУЗ-ийн гишүүн
.....

Гарын үсэг:

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
“.....”К-ийн
ТУЗ-ийн
гишүүн.....

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн Биржийн албан хэрэгцээнд/

Өргөдөл хүлээн авсан ажилтны овог, нэр:	Өргөдөл хүлээн авсан огноо, цаг, минут:	Өргөдөл түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ БОЛОН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН МЭДЭГДЭЛ

Огноо

I. Үнэт цаас гаргагчийн мэдэгдэл:

1. Үнэт цаас гаргагч[Үнэт цаас гаргагч хуулийн этгээд, түүнийг төлөөлж] бид өөрсдийн мэдлэг чадвараа бүрэн ашиглан дараах ажиллагааг хийж гүйцэтгэсэн гэдгээ мэдэгдэж байна:
 - 1.1. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК /цаашид “Бирж” гэх/-ийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам” болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үнэт цаасыг гаргаж бүртгүүлэх, нийтэд санал болгох, танилцуулахтай холбоотой шаардагдах бүхий л баримт бичгийг үнэн зөвөөр бүрдүүлсэн.
 - 1.2. Үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой Биржийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”-д тусгагдсан үнэт цаас гаргагчид тавигдах шаардлага болон үнэт цаасны нөхцөл шалгуурыг бүрэн хангасан.
 - 1.3. “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасан болон хууль, тогтоомжоор шаардах бусад мэдээллийг өргөдлийн хамт хүргүүлж байгаа баримт бичигт тусгасан. Хэрэв сүүлчийн хувилбар хүргэгдээгүй бөгөөд мэдээлэл дутуу бол дутуу мэдээллийг тусгаж, залруулан хүргүүлнэ.
 - 1.4. Үнэт цаас бүртгүүлэх, арилжих зөвшөөрөл авахтай холбоотойгоор үнэт цаас гаргагчийн өргөдөлд тусгасан мэдээлэлтэй зөрчилдөх ямар нэгэн баримт материал байхгүй болно. Хэрэв зөрчилдөх материал байх тохиолдолд Биржид нэн даруй мэдээлнэ.
 - 1.5. Энэхүү мэдэгдэлд тусгасан мэдээллийг хугацаанд нь мэдэгдээгүй, худал, ташаа мэдээлэл хүргүүлсэн нь нотлогдвол түүнээс үүсэх хариуцлагыг бид бүрэн хариуцна.
2. Үнэт цаас гаргагч нь Биржид бүртгэлтэй байх хугацаанд дараах үйл ажиллагааг тогтмол авч хэрэгжүүлэхийг мэдэгдэж байна:
 - 2.1. Бид өөрийн эрх мэдлийн хүрээнд Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, тогтоомж болон Хороо, Биржийн холбогдох журам, зааврыг бүрэн дагаж, биелүүлэн ажиллана.
 - 2.2. Манай үнэт цаас Биржид бүртгэгдсэн нөхцөлд Биржийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам” болон бусад холбогдох журам, заавраар тогтоосон шалгуур шаардлагыг хангаж ажиллах ба Бүртгэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ хариуцлагатай биелүүлж, цаашид зохих дүрэм, журмыг баримталж ажиллана.
 - 2.3. Өргөдлийг хүлээн авч, үнэт цаасыг бүртгэх тухай шийдвэр гарсан тохиолдолд зохих хууль, журмын дагуу арилжааг эхлүүлэх хүсэлтээ

Санхүүгийн Зохицуулах Хороо /цаашид “Хороо” гэх/ болон Биржид хүргүүлнэ.

- 2.4. Үнэт цаас гаргагч нь “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам” болон бусад холбогдох хууль, дүрэм, журамтай танилцсан бөгөөд үнэт цаас гаргагчийн үнэт цаас нь бүртгэлтэй хэвээр байх эсэх нь одоо болон ирээдүйд хүчин төгөлдөр мөрдөгдөх хууль дүрэм журмыг хэрхэн дагаж мөрдөхөөс хамааралтай болохыг хүлээн зөвшөөрч байна.
3. Дараах зүйлсийг Биржийн журамд заасан тогтоосон хугацаанд цаг алдалгүй хүргүүлнэ:
- 3.1. Биржийн зүгээс хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор болон зах зээлийн үйл ажиллагааг хэвийн хангах зорилгоор шаардсан мэдээлэл баримтыг хүргүүлэх;
- 3.2. Биржийн зүгээс “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор шаардсан тайлбар, баримт бичиг, мэдээллийг хүргүүлж, хамтран ажиллах;
- 3.3. Холбогдох хууль, журмын дагуу Хороо болон хөрөнгө оруулагчдад хүргэсэн мэдээллийг биржид нэгэн зэрэг ирүүлэх;
- 3.4. Мөн өөрт шууд холбогдох асуудалд хариу тайлбар гаргаж өгөх.
4. ҮЦГ нь төлбөрийн чадваргүй болох, дампуурах, татан буулгах нөхцөлд хүргэх аливаа өр төлбөргүй ба хөрөнгийн багцаас орж ирэх мөнгөн урсгал нь ХБҮЦ-аар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц гэдгийг баталгаажуулж байна.
5. Бүртгүүлэх өргөдлийг хүлээн авч, хянах үйлчилгээний хөлс төгрөгийг ... оны ... дугаар сарын ...-ны өдөр..... банкны дансанд төлсөн нь үнэн болно. /Төлбөр төлсөн баримтын хуулбарыг хавсаргах/
6. Хэрэв Бирж нь өргөдөлд тусгасан үнэт цаасыг бүртгээгүй, бүртгэхээс татгалзсан тохиолдолд үнэт цаас гаргагчийн төлсөн “өргөдлийг хүлээн авч, хянах үйлчилгээний хөлс” нь буцаан олгогдохгүй болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 11.4-т заасан хугацаанд тогтоосон хувь хэмжээгээр үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлсийг Биржид төлөхөө мэдэгдэж байна.

Баталгаажуулсан:

Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
“.....”К-ийн
.....

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

Баталгаажуулсан:

Овог, нэр:

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
“.....”К-ийн
.....

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

II. Үүсгэн байгуулагчийн мэдэгдэл:

Үнэт цаас гаргагчийг үүсгэн байгуулагч [Үүсгэн байгуулагч, түүнийг төлөөлж] бид

1. Үнэт цаасны танилцуулга, түүнд холбогдох баримт материалд орсон мэдээлэл нь бүгд үнэн зөв, бүрэн гүйцэд гэж үзэж байна. Худал, ташаа, орхигдуулсан мэдээллийн улмаас үүсэх хариуцлагыг ХБҮЦ гаргагчтай хамтран бүрэн хариуцна.
2. Үүсгэн байгуулагчийн үйл ажиллагаа тасралтгүй хэвийн явагдаж байгаа ба материаллаг тодорхой бус байдал үүсээгүй болохыг мэдэгдэж байна.
3. Хөрөнгийн багцаас орж ирэх мөнгөн урсгал нь ХБҮЦ-аар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц гэдгийг баталгаажуулж байна.

Баталгаажуулсан:

Овог, нэр:

Албан тушаал: Үүсгэн байгуулагч
“.....”К-ийн
ТУЗ-ийн дарга

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

Баталгаажуулсан:

Овог, нэр:

Албан тушаал: Үүсгэн байгуулагч
“.....”К-ийн
.....

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

АНДЕРРАЙТЕРИЙН МЭДЭГДЭЛ

Огноо:

Бид [Андеррайтерийн байгууллага, түүнийг төлөөлж] байршилтай, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК /цаашид “Бирж” гэх/-ийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 2.4-т заасны дагуу ХБҮЦ гаргагчийн үнэт цаасыг олон нийтэд санал болгоход андеррайтерийн үүрэг гүйцэтгэх бөгөөд журамд заасны дагуу дараах мэдэгдлийг гаргаж байна:

1. ХБҮЦ гаргагчийн үнэт цаас бүртгүүлэх өргөдлийн маягт болон Биржийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу шаардлагатай бүхий л материалыг Биржид хүргүүлсэн.
2. Бид уульд заасан хэм хэмжээний хүрээнд өөрсдийн хүчин чадлаа дайчлан бодитой лавлагааг хийж, судалсаны үр дүнд доорх зүйлсийг баталгаажуулсанаа мэдэгдэж байна:
 - 2.1.1.Андеррайтер нь Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, дүрэм журмын бүхий л нөхцлийг мөрдөж ажилласан ба хүргүүлсэн баримт бичиг нь шаардлагатай мэдээллүүдийг бүрэн агуулсан, баримт материал орхигдуулаагүй болно.
 - 2.1.2.Үнэт цаасны танилцуулга болон үнэт цаас бүртгүүлэх өргөдөлтэй хамт хүргүүлж буй андеррайтерийн дүгнэлтийг үнэн зөв, бодитой, бүрэн хийгдсэн гэж үзэж байна.
 - 2.1.3.Андеррайтер нь ХБҮЦ гаргагч болон түүний хувь эзэмшигчидтэй холбоо хамааралгүй бөгөөд бие даасан хөндлөнгийн дүгнэлт гаргасан.
 - 2.1.4.Бид андеррайтерийн дүгнэлт гаргах, үнэт цаасны танилцуулга бэлтгэх зэрэг ажиллагаанд шаардагдах туршлагатай, мэргэшсэн, холбогдох саналаа илэрхийлэх хангалттай нөөц бололцоотой гэж үзэж байна.
 - 2.1.5.ХБҮЦ гаргагчийн удирдлагууд нь компанийн бизнесийн үйл ажиллагааг дангаар болон бие даан явуулах туршлага, мэдлэг, чадвартай бөгөөд бүртгэлтэй үнэт цаас гаргагч болсноор хүлээх үүрэг хариуцлагаа ухамсарласан.
 - 2.1.6.ХБҮЦ гаргагч нь бүртгүүлэхээс өмнөх болон бүртгүүлсэний дараах үнэт цаас гаргагчийн дагаж мөрдөх дүрэм журам, удирдлагын үүрэг хариуцлагатай холбоотой дотоод дүрэм журмыг бий болгосон гэж үзэж байна.

Баталгаажуулсан:

Баталгаажуулсан:

Овог, нэр:

Овог, нэр:

Албан тушаал: Андеррайтерийн
“.....”К-ийн
.....

Албан тушаал: Андеррайтерийн
“.....”К-ийн
.....

Гарын үсэг:

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО,
ХАДГАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГАД
ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ**

Хэнд:

№

Огноо:

ҮЗҮҮЛЭЛТ		ҮНЭТ ЦААС БҮРТГҮҮЛЭХ	ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРОХ	ҮНЭТ ЦААС БҮРТГЭЛЭЭС ХАСАХ
Мэдэгдлийн агуулга:	 тухай		
Үндэслэл:				
Санхүүгийн хэрэгсэл:				
Үнэт цаасны нэр:				
Үнэт цаасны код: /үсгэн, тоон/				
Үнэт цаасны төрөл: /энгийн, давуу эрхийн/				
Үнэт цаасны хэлбэр: /биет, биет бус/				
Нийт үнэт цаасны тоо: /ширхэг/				
Энгийн	тоо /ширхэг/			
	хувь /%/			
Давуу эрхийн	тоо /ширхэг/			
	хувь /%/			
Олон нийтийн эзэмшил	тоо /ширхэг/			
	хувь /%/			
Хаалттай хүрээнд	тоо /ширхэг/			
	хувь /%/			
Үнэт цаасны нэрлэсэн үнэ: /төгрөг/				
Үнэт цаасны нийт үнийн дүн: /төгрөг/				
Үнэт цаасны нөхцөл: /хямдруулсан, хөрвөх, тогтмол хүүтэй, хугацаанаас өмнө эргүүлэн				

татах гэх мэт/			
Үнэт цаасны хүү/өгөөжийн хувь хэмжээ:			
Үнэт цаасны хугацаа:			
Үнэт цаасны хүү төлөгдөх хугацаа /давтамж/:			
Бусад:			

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/...../

ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ГЭРЭЭ

Он сар өдөр

№

Улаанбаатар хот

Нэг талаас: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК /цаашид Бирж гэх/, түүнийг төлөөлж Хяналт, зохицуулалтын газрын захирал,

Нөгөө талаас: “.....” ХХК /ХК/ /цаашид Үнэт цаас гаргагч гэх/, түүнийг төлөөлж нар, /хамтад нь Талууд гэх/

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан Санхүүгийн зохицуулах хорооны болон Монголын хөрөнгийн биржийн холбогдох дүрэм, журам, зааврын хүрээнд Үнэт цаас гаргагчийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Биржид бүртгэх, арилжих, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор дараах нөхцлийг харилцан тохиролцож, энэхүү гэрээг байгуулав.

I. Ерөнхий зүйл

1. Энэхүү гэрээгээр ХК /ХХК/-иас гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Биржид бүртгэн авах, арилжих, шимтгэл хураамж төлөх, хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
2. Гэрээтэй холбогдон үүсч болох бусад харилцааг холбогдох хууль эрхзүйн актын дагуу зохицуулна.
3. ХБҮЦ-ыг биржийн үнэт цаасны бүртгэлээс хассанаар энэхүү гэрээ дуусгавар болно.

II. Биржийн эрх, үүрэг

4. Бирж нь-ийн гаргасан төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий ширхэг ХБҮЦ-ыг үнэт цаасны бүртгэлд бүртгэж, арилжааг зохион байгуулах ажиллагааг зохих дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэнэ.
5. ХБҮЦ-ны арилжаатай холбоотой судалгаа болон зөвшөөрөгдсөн бусад мэдээллийг үнэт цаас гаргагчийн хүсэлтээр гаргаж өгнө.
6. ХБҮЦ-ны талаарх дэлгэрэнгүй мэдээллээр сонирхогч этгээдийг хангана.
7. Үнэт цаасыг үе шаттайгаар хэсэгчлэн гаргахыг зөвшөөрсөн тохиолдолд Биржид бүртгэгдсэн нийт төгрөгийн ХБҮЦ-аас төгрөгийн ХБҮЦ-ыг эхний ээлжинд арилжаалах зөвшөөрлийг олгох ба дараагийн ээлжийн ХБҮЦ-ны нэмэлт материал, санал болгон арилжаалах үнэ ханш тодорхой болсны дараа тухайн үе шатны ХБҮЦ-ыг арилжаалах зөвшөөрлийг олгоно.
8. Үнэт цаас гаргагчийн бүртгүүлсэн ХБҮЦ-ны нийт үнийн дүнгийн ... хувиар тооцон бүртгэх үйлчилгээний хөлс авна.

9. Арилжсан ХБҮЦ-ны үнийн дүнгээс хувиар тооцон арилжааны шимтгэл тооцож авна.
10. Бирж нь үнэт цаастай холбоотой шаардлагатай мэдээ, тайлан, бичиг баримтыг үнэт цаас гаргагчаас гаргуулан авах эрхтэй. Тайлан, мэдээний бүрдэл, хэлбэр, хэмжээнд тавигдах шаардлага, холбогдох маягтын загварыг Биржээс тогтоож болно.
11. Бирж нь Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ны төлбөрийн эргэн төлөлтөд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд зохих арга хэмжээг авахуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад хандах эрхтэй.

III. Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг

12. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан холбогдох эрх зүйн актууд, Монголын хөрөнгийн биржийн дүрэм, журам, зааврыг дагаж мөрдөнө.
13. Үнэт цаас гаргагч нь арилжигдсан ХБҮЦ-ны үндсэн болон хүүгийн төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж барагдуулах ба үнэт цаасны төлбөр тооцоог саадгүй хийх нөхцлөөр хангагдсан байна.
14. Шаардлагатай тохиолдолд төлбөрийн эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлнэ.
15. Бүртгэх үйлчилгээний хөлс, арилжааны шимтгэлийг энэ гэрээ болон ХБҮЦ-ны бүртгэлийн журамд заасны дагуу тогтоосон хугацаанд төлнө.
16. Шаардлагатай тайлан, мэдээлэл, бичиг баримтыг Биржээс тогтоосон хэлбэр, маягтын дагуу өөрөө, эсхүл үйлчилгээ үзүүлэгч этгээдээр дамжуулан Биржид цаг тухайд нь гаргаж ирүүлэх үүрэг хүлээнэ.
17. Тайлан, мэдээллийг цахим болон хэвлэмэл байдлаар ирүүлэх ба Биржид ирүүлсэн мэдээ мэдээллийн үнэн зөвийг бүрэн хариуцна.
18. ХБҮЦ-ны арилжаа, хөлс хураамжтай холбоотой мэдээллийг Биржээс гаргуулан авах эрхтэй.
19. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан Санхүүгийн зохицуулах хорооны болон Биржийн холбогдох дүрэм, журам, заавар, мөн энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүйгээс аливаа этгээдэд учирсан хохирлыг Үнэт цаас гаргагч, түүний холбогдох албан тушаалтан бүрэн хариуцна.

IV. Бусад

20. Гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд хувиуд адил хүчинтэй.
21. Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.
22. Гэрээтэй холбогдон үүссэн аливаа маргаантай асуудлаар талууд зөвшилцөж эс чадвал шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Биржийг төлөөлж:

Үнэт цаас гаргагчийг төлөөлж:

Хянал зохицуулалтын газрын
захирал:

.....ХХК /ХК/-ийн

.....

/...../

.....

/...../